

## ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,  
2014 оны 7-р сарын 2-ны байдлаар*


2014 оны 7-р сарын 2-ны байдлаар хүнсний гол нэрийн барааны үнийг өмнөх сартай болон, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 1.1 хувиар буурсан байна.

**Махны дундаж үнэ:** 2014 оны 7-р сарын 2-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сарынхаас 5.5 хувь, үхрийн ястай махны үнэ 2.3 хувь, үхрийн цул мах 2.0 хувь, ямааны махны үнэ 1.9 хувиар буурч, адууны махны үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхоос хонины ястай махны үнэ 3.5 хувь, үхрийн ястай махны үнэ 1.3 хувиар буурч, бусад махны үнэ өөрчлөлтгүй байна.

2014 оны 7-р сарын 2-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7265 төгрөг, үхрийн /ястай/ мах 8525 төгрөг, үхрийн цул мах 10565 төгрөг, адууны мах 6605 төгрөг, ямааны мах 6200 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


**Зураг 1.** Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ



**Гурилын үнэ:** 2014 оны 7-р сарын 2-ны байдлаар дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ өмнөх сарынхаас 0.3 хувь, дээд зэргийн савласан гурилын үнэ өмнөх сарынхаас 2.5 хувь, 1-р зэргийн гурилын үнэ өмнөх сарынхаас 6.0 хувь, 2-р зэргийн гурилын үнэ 2.3 хувиар өссөн байна. Харин өмнөх 7 хоногийнхоос дээд зэргийн савласан гурилын үнэ 1.8 хувиар өсч, бусад гурилын үнэ өөрчлөлтгүй байлаа.

**Будаа, элсэн чихрийн дундаж үнэ:** 2014 оны 7-р сарын 2-ны байдлаар цагаан будааны үнэ, элсэн чихрийн үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна (Зураг2).

**Зураг2**



**Төмс, хүнсний ногооны дундаж үнэ:** 2014 оны 7-р сарын 2-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад луувангийн үнэ 10.2 хувь, төмсний үнэ 0.5 хувь, байцааны үнэ 0.7 хувиар өсч, манжингийн үнэ, сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхоос хүнсний ногооны үнэ өөрчлөлтгүй байлаа.

**Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ:** 2014 оны 7-р сарын 2-ны байдлаар өмнөх сарынхаас савласан /1 литрийн/ сүүний үнэ 1.4 хувь, “Элекстер” /0.5 л/ савласан сүүний үнэ 1.0 хувь, задгай сүүний үнэ 1.0 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос сүүний үнэ өөрчлөлтгүй байлаа.

Ургамлын тосны үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй, өндөгний үнэ өмнөх сарынхаас 5.7 хувь, өмнөх 7 хоногийнхоос 1.3 хувиар буурч, цөцгийн тосны үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос 11.1 хувиар өссөн байна.

### **Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар**

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, мах, цагаан будаа, малын сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

**Гурилын үнэ:** 2014 оны 7-р сарын 2-ны байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 800-1300 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Гурилын үнэ өмнөх 7 хоногийнхоос Дундговь аймагт 50 төгрөгөөр өсч бусад аймагт өөрчлөлтгүй байна.

Говьсүмбэр аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 800 төгрөг байхад, Булган аймагт 1300 төгрөг байгаа нь өндөр үнэ байна.

**Махны үнэ:** 2014 оны 7-р сарын 2-ны байдлаар хонины махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Дархан-Уул аймагт 100-500 төгрөгөөр өсч, Баян-Өлгий, Говь-Алтай, Архангай, Булган, Хөвсгөл, Говьсүмбэр, Дундговь, Сэлэнгэ, Дорнод аймагт 40-500 төгрөгөөр буурсан байна.

Хонины махны үнэ Өмнөговь аймагт 8000 төгрөг байгаа нь өндөр бөгөөд Баян-Өлгий аймагт 6300 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байв.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Ховд, Дархан-Уул аймагт 400-500 төгрөгөөр өсч, Архангай, Говьсүмбэр, Төв, Дорнод аймагт 200-1000 төгрөгөөр буурсан байна. Үхрийн махны үнэ Төв аймагт 9000 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ бөгөөд Баян-Өлгий аймагт 6500 төгрөгөөр худалдаалагдсан нь хямд үнэ байв.

Ямааны махны үнэ Ховд, Өвөрхангай аймагт 200-500 төгрөгөөр өсч, Говь-Алтай, Архангай аймагт 300-500 төгрөгөөр буурсан байна. Ямааны мах Баян-Өлгий аймагт хямд буюу 5500 төгрөг байхад Өмнөговь аймагт 7800 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ байна.

**Малын сүүний үнэ:** 2014 оны 7-р сарын 2-ны байдлаар малын сүү аймагт 600-2500 төгрөгийн үнэтэй худалдаалагдсан байна. Сүүний үнэ Увс, Баянхонгор, Өвөрхангай, Дархан-Уул, Дорнод аймагт 70-200 төгрөгөөр буурсан байна. Өмнөговь аймагт хамгийн /2000 төг/ өндөр үнэтэй байна.

**Цагаан будаа, элсэн чихрийн үнэ:** 2014 оны 7-р сарын 2-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх 7 хоногийнхоос Баян-Өлгий, Орхон аймагт 30-70 төгрөгөөр өсч, бусад аймагт өөрчлөлтгүй байна. Аймгуудад цагаан будаа 1 кг нь 2000-2400 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх 7 хоногийнхоос бүх аймагт өөрчлөлтгүй байна. Элсэн чихэр 1 кг нь 1530-2000 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.

**Улаанбаатар хотын гол нэрийн зарим барааны үнэ, үнийн индекс**  
(2014 оны 7-р сарын 2-ны байдлаар өмнөх сар болон 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулснаар)

**Хүснэгт 1.**

№	Барааны нэр		2014 он			VII - 2	VII - 2
			6 сарын дундаж үнэ	6 сарын 25-ны үнэ	7 сарын 2-ны үнэ	% Vi сар	% VI - 25
1	"Алтан тариа" гурил	дээдийн дээд, савласан, кг	1 660	1 635	1 665	100.3	101.8
		дээд, савласан, кг	1 205	1 235	1 235	102.5	100.0
		I зэрэг, задгай, кг	910	965	965	106.0	100.0
		2-р зэрэг, савласан	665	680	680	102.3	100.0
2	Талх	"Атар", 600 гр	835	840	840	100.6	100.0
		"Зууван чех", 600 гр	1 020	1 030	1 030	101.0	100.0
3	Цагаан будаа, кг		2 345	2 345	2 345	100.0	100.0
4	Хонины мах, ястай, кг*		7 685	7 530	7 265	94.5	96.5
5	Үхрийн мах, ястай, кг*		8 730	8 635	8 525	97.7	98.7
6	Үхрийн мах, цул, кг*		10 780	10 565	10 565	98.0	100.0
7	Адууны мах, ястай, кг*		6 605	6 605	6 605	100.0	100.0
8	Ямааны мах, ястай, кг*		6 085	6 200	6 200	101.9	100.0
9	Сүү	задгай, л	1 515	1 500	1 500	99.0	100.0
		"Элекстер", 0.5 л	1 050	1 040	1 040	99.0	100.0
		"Шинэ Сүү", л	2 135	2 105	2 105	98.6	100.0
10	Тараг, савласан, 900 гр, "Цөцгийтэй"		2 115	2 115	2 115	100.0	100.0
11	Цөцгийн тос, 250 гр		2 360	2 550	2 550	108.1	100.0
12	Ургамлын тос, "Кларина", л		3 120	3 120	3 120	100.0	100.0
13	Элсэн чихэр, кг		1 655	1 655	1 655	100.0	100.0
14	Ногоон цай, савласан, 2 кг		4 545	4 545	4 545	100.0	100.0
15	Өндөг, ш		385	375	365	94.8	97.3
16	Алим, "Фүжи" сортын, кг		3 800	3 965	3 965	104.3	100.0
17	Төмс, дотоод, кг		1 010	1 015	1 015	100.5	100.0
18	Лууван, дотоод, кг		1 865	2 055	2 055	110.2	100.0
19	Байцаа, импортын, кг		1 400	1 410	1 410	100.7	100.0
20	Манжин, дотоод		1 625	1 625	1 625	100.0	100.0
21	Сонгино, бөөрөнхий, импортын, кг		1 325	1 325	1 325	100.0	100.0
22	Шатахуун	Аи-80 автобензин, л	1 550	1 550	1 550	100.0	100.0
		Аи-92 автобензин, л	1 660	1 660	1 660	100.0	100.0
		Дизелийн түлш, л	1 790	1 790	1 790	100.0	100.0
<b>ДҮН</b>						<b>98.9</b>	<b>98.9</b>

2014 оны 7-р сарын 2-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 1.1 хувиар буурсан байна.

\* Улаанбаатар хотод борлуулагдаж буй махны дундаж үнийг хүнсний захуудын махны борлуулалтын хэмжээгээр жигнэж тооцсон.

**Улаанбаатар хотын хүнсний гол нэрийн барааны үнэ, хүнсний зах, дэлгүүрээр**  
(2014 оны 7-р сарын 2-ны байдлаар)

Хүснэгт 2.

		хэмжих нэгж	"Баянзүрх" зах	"Замбала" супер-маркет	"Хүчит шонхор" зах	"Бөмбөгөр" хт	"Меркури" зах	"Барс" хт	"Таван эрдэнэ" зах	"Хар хорин" зах	Номин Супер-маркет	Макс Супер-маркет	Оргил Супер-маркет	
1	"Алтан тариа" задгай гурил	дээд	кг	1200	1212	1200	1100	1150	1300	1200	1158	1137		
		1-р зэрэг	кг	1000	1032	1000	900	950	1000	900		938		
2	"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	кг		1860		1500	1800	1600	1700	1499	1710		
		дээд	кг	1250	1250	1300	1100	1500	1200	1350	1200	1149	1180	1110
		1-р зэрэг	кг	1050	1070	1050	950	1100	1000	1050	850	939	980	780
		2-р зэрэг	кг	700	810	600	600		650	700	600		700	750
3	"Алейка" дээд гурил	кг	1400		1400	1200	1500	1200	1350	1400		1306	1109	
4	Сүү	Сүү ХК 1л	л	2000	2100	2100	2000	2300	1900	2300	2100	2299	2050	1980
		Сүү ХК 0.5л	л	1000	990	1000	1000	1200	950	1200	1000	1099	1050	950
		Задгай	л	1500		1400				1600	1500			
5	Тараг, Цөцгийтэй	л	2200	2100	2100	2000	2200	2000	2100	2100	2199	2160	2100	
6	Талх	Атар	ш	850	850	850	800	900	800	900	809	850	830	
		Зууван чех	ш	1000	950	1000	950	1200	1000	1100	950	1079	1100	1000
7	Будаа	цагаан	кг	2300		2200	2200		2200	2500	2200	2769	2390	
		шар	кг	1500		1500	1500		1500	1600	1500		1920	
8	Цөцгийн тос, 250 гр	кг	2300		2500	2600	3000	2400	2600	2500		2500		
9	Ургамлын тос	л	3000	3080	2900	3000	3300	3000	3300	3000	3149	3450	3160	
10	Ногоон цай, Гүрж	кг	4200	4320	4800	4600		4500	4500	4600		4820		
11	Элсэн чихэр	кг	1600		1500	1500	1900	1500	1600	1700		1950		
12	Хонины мах	ястай	кг	7300		7000	8300	9500	7800	9800	7000	8800	6400	
		цул	кг	8300		8000					8000		7300	
13	Үхрийн мах	ястай	кг	8500		8300	9500	9800	9000	9800	8500	10500	7600	
		цул	кг	11000		10000	11000	12000	##	12000	10000	11500	9400	
14	Адууны мах, ястай	кг	6800		6800	7000				6300				
15	Ямааны мах, ястай	кг	6000		6200	6400				6200				
19	Төмс, монгол	кг	900	1200	900	1000	1200	800	1200	900	1049	800	1200	
20	Лууван, монгол	кг	1800	2000	2500	2000	2500	1500	2500	1800	1999	2000	2000	
21	Байцаа, монгол	кг	1200		1200	1500	1800	1200	1500	1200	1499	1500	1500	
22	Манжин, монгол	кг	1500	1800	1500	1800	2000	1200	1500	1500	1599	2000	1500	
23	Сонгино, хятад бөөрөнхий	кг	1200	1300	1200	1300	1500	1200	1500	1200	1299	1400	1500	
24	Алим, фужи	кг	3500	5990	3500	3000	3500	3000	4500	3500	4399	3900	4800	
25	Өндөг, ОХУ	ш	330	440	330	330	420	320	340	330	430	340	400	

Аймгийн төвүүдэд зарагдаж байгаа хүнсний гол нэрийн барааны үнэ, 2014 оны 7-р сарын 2-ны байдлаар

Аймаг	Хонины мах									
	6 сарын дундаж	5 сарын 7	5 сарын 14	5 сарын 21	5 сарын 28	6 сарын 4	6 сарын 11	6 сарын 18	6 сарын 25	7 сарын 2
<b>Баруун бүс</b>										
Баян-Өлгий	6 403	6 500	6 500	6 500	6 500	6 500	6 500	6 270	6 340	6 300
Говь-Алтай	7 600	7 200	7 800	7 800	7 500	7 800	7 800	7 500	7 300	7 300
Завхан	7 500	7 500	7 500	7 500	7 500	7 500	7 500	7 500	7 500	7 500
Увс	7 208	7 370	7 500	7 500	7 330	7 330	7 330	7 170	7 000	7 000
Ховд	7 875	8 500	8 500	7 500	7 500	8 000	8 000	8 000	7 500	8 000
<b>Хангайн бүс</b>										
Архангай	8 000	8 500	8 000	8 500	8 000	8 000	8 000	8 500	7 500	7 000
Баянхонгор	7 975	7 800	7 500	7 800	7 800	8 000	8 200	8 200	7 500	7 800
Булган	8 000	8 000	8 000	8 000	8 000	8 000	8 000	8 000	8 000	7 500
Орхон	7 858	8 500	8 500	8 500	8 270	8 270	7 830	7 830	7 500	7 500
Өвөрхангай	7 650	7 500	7 800	7 800	7 800	7 800	7 800	7 500	7 500	7 800
Хөвсгөл	8 250	8 000	8 000	8 000	8 500	8 500	8 500	8 500	7 500	7 000
<b>Төвийн бүс</b>										
Говьсүмбэр	6 825	7 000	7 000	7 000	7 000	7 000	7 000	6 800	6 500	6 200
Дархан-Уул	7 600	8 300	8 300	8 350	8 000	8 200	7 600	7 400	7 200	7 300
Дорноговь	7 500	7 500	7 330	7 500	7 500	7 500	7 500	7 500	7 500	7 500
Дундговь	7 900	8 000	8 000	8 000	8 000	8 000	8 000	7 800	7 800	7 500
Өмнөговь	8 000	8 000	8 000	8 170	8 000	8 000	8 000	8 000	8 000	8 000
Сэлэнгэ	7 950	7 500	7 800	7 800	7 800	7 800	8 000	8 000	8 000	7 800
Төв	7 500	8 000	8 000	8 000	8 000	7 500	7 500	7 500	7 500	7 500
<b>Зүүн бүс</b>										
Дорнод	7 350	7 500	7 500	7 500	7 500	7 200	7 500	7 500	7 200	7 000
Сүхбаатар	7 275	7 000	7 500	7 500	7 500	7 300	7 300	7 000	7 500	7 500
Хэнтий	7 500	8 000	8 000	7 500	7 500	7 500	7 500	7 500	7 500	7 500

■ Буурсан үнэ  
■ Өссөн үнэ

Улаанбаатар хотын автобензин, дизель, хийн түлшний дундаж үнэ, шатахуун түгээх станцаар (2013 оны 7-р сарын 2-ны байдлаар)

		Жаст ойл	Петровис	Магнай трейд	Сод монгол	Шунхлай
1	Аи-95	1890	1890	1890	1890	
2	Аи-80	1550	1550	1550	1550	1550
3	Аи-92	1660	1660	1660	1660	1660
4	Мон-93		1660			
5	Дизель түлш	1790	1790	1790	1790	1790

Аймаг	Үхрийн мах									
	6 сарын дундаж	5 сарын 7	5 сарын 14	5 сарын 21	5 сарын 28	6 сарын 4	6 сарын 11	6 сарын 18	6 сарын 25	7 сарын 2
<b>Баруун бүс</b>										
Баян-Өлгий	6 063	6 000	6 000	6 170	6 000	6 250	6 000	5 500	6 500	6 500
Говь-Алтай	8 500	9 000	8 500	8 500	8 500	8 500	8 500	8 500	8 500	8 500
Завхан	8 500	8 500	8 500	8 500	8 500	8 500	8 500	8 500	8 500	8 500
Увс	7 375	7 000	7 000	7 500	7 500	7 500	7 500	7 500	7 000	7 000
Ховд	7 875	8 000	8 000	7 500	8 000	8 000	8 000	8 000	7 500	8 000
<b>Хангайн бүс</b>										
Архангай	8 650	8 800	8 800	9 200	8 500	8 500	8 800	8 800	8 500	8 300
Баянхонгор	8 125	8 500	8 500	8 500	8 500	8 500	8 000	8 000	8 000	8 000
Булган	8 500	8 000	8 500	8 500	8 500	-	8 500	8 500	8 500	8 000
Орхон	8 748	9 000	9 170	9 170	8 830	8 830	8 830	8 830	8 500	8 500
Өвөрхангай	9 000	9 000	9 000	9 000	9 000	9 000	9 000	9 000	9 000	9 000
Хөвсгөл	8 250	8 000	8 500	8 500	8 500	8 500	8 500	8 500	7 500	7 500
<b>Төвийн бүс</b>										
Говьсүмбэр	7 825	7 800	7 800	8 000	8 000	8 000	8 000	7 800	7 500	7 200
Дархан-Уул	7 900	8 800	8 800	9 000	8 300	8 100	8 100	8 000	7 400	7 800
Дорноговь	9 500	9 000	9 500	9 500	9 500	9 500	9 500	9 500	9 500	9 500
Дундговь	-	-	-	-	-	-	-	-	-	-
Өмнөговь	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сэлэнгэ	9 000	8 500	9 000	9 500	9 500	9 500	9 000	9 000	8 500	8 500
Төв	9 750	10 000	10 000	10 000	9 000	9 000	10 000	10 000	10 000	9 000
<b>Зүүн бүс</b>										
Дорнод	8 950	9 500	9 500	9 300	9 500	9 000	9 000	9 000	8 800	8 500
Сүхбаатар	7 875	7 500	8 000	8 000	8 000	8 000	8 000	7 500	8 000	8 000
Хэнтий	9 375	9 500	9 500	9 500	9 500	9 500	9 500	9 500	9 000	9 000











Аймаг	Сүү /савлаагүй/									
	6 сарын дундаж	5 сарын 7	5 сарын 14	5 сарын 21	5 сарын 28	6 сарын 4	6 сарын 11	6 сарын 18	6 сарын 25	7 сарын 2
<b>Баруун бүс</b>										
Баян-Өлгий	1 050	2 000	1 500	1 500	1 300	1 000	1 000	1 000	1 200	1 200
Говь-Алтай	1 275	2 500	2 500	2 500	2 500	1 500	1 300	1 300	1 000	1 000
Завхан	1 400	2 000	2 000	2 000	2 000	1 800	1 300	1 300	1 200	1 200
Увс	893	1 500	1 300	1 200	1 000	930	900	870	870	800
Ховд	1 425	2 000	2 000	2 000	2 000	1 500	1 500	1 500	1 200	1 200
<b>Хангайн бүс</b>										
Архангай	1 175	2 000	1 500	1 500	1 500	1 500	1 200	1 000	1 000	1 000
Баянхонгор	1 425	2 500	2 500	2 000	2 000	1 500	1 500	1 500	1 200	1 000
Булган	850	1 500	1 300	1 300	1 000	1 000	800	800	800	800
Орхон	750	1 500	1 300	1 000	800	800	800	800	600	600
Өвөрхангай	1 713	2 100	2 300	2 300	2 200	2 000	1 900	1 500	1 450	1 200
Хөвсгөл	850	1 800	1 500	1 500	1 200	900	900	800	800	800
<b>Төвийн бүс</b>										
Говьсүмбэр	1 075	1 100	1 200	1 300	1 300	1 200	1 100	1 000	1 000	1 000
Дархан-Уул	700	1 200	1 000	1 000	800	700	700	700	700	630
Дорноговь	1 800	2 000	1 800	1 800	1 800	1 800	1 800	1 800	1 800	1 800
Дундговь	1 600	1 600	1 600	1 600	1 600	1 600	1 600	1 600	1 600	1 600
Өмнөговь	2 500	3 000	3 000	3 000	3 000	3 000	2 500	2 500	2 000	2 000
Сэлэнгэ	700	1 100	1 100	800	800	800	700	700	600	600
Төв	850	1 300	1 300	1 200	1 200	1 000	800	800	800	800
<b>Зүүн бүс</b>										
Дорнод	775	1 200	1 000	1 000	1 000	800	800	800	700	600
Сүхбаатар	1 175	1 700	1 500	1 300	1 300	1 000	1 000	1 700	1 000	1 000
Хэнтий	1 425	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 200	1 000







